



Каритас  
Монгол



# ӨРХИЙН АМЬЖИРГАА

СУРГАЛТЫН ТӨВ



*Тамгын зураг*



## БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Дэлхийн 169 оронд хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг Каритас Интернэйшналис олон улсын байгууллагын гишүүн Каритас Монгол төрийн бус байгууллага нь ядуурлыг бууруулж, иргэд болон зорилтот бүлгийг чадавхижуулах замаар нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой урт богино хугацааны төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг ашгийн бус байгууллага юм. Каритас Монгол байгууллагын хэрэгжүүлж буй төслүүдийн нэг нь “Өрхийн амьжиргаа” сургалтын төв юм.

## СУРГАЛТЫН ТӨВИЙН ЗОРИЛГО

“Өрхийн амьжиргаа” сургалтын төв нь ажилгүй, орлого багатай, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд оёдол эсгүүр, гар урлал дээр суурилсан мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг онол, практик хосолсон байдлаар олгож, улмаар өрхийн орлогоо нэмэгдүүлэх чадвартай иргэд ба зорилтот бүлгийг бэлтгэх зорилготойгоор 2009 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

## СУРГАЛТЫН БҮТЭЦ:

“Өрхийн амьжиргаа” сургалтын төв нь доорх үндсэн гурван чиглэлээр тус бүр 120 цагийн онол практик хосолсон хөтөлбөрөөр сургалтыг олгодог.

Манай сургалтын төв нь мэргэжлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан бөгөөд сургалтын явцад шаардлагатай биет материал, бүс бараа, түүхий эдийг ашигладагаараа давуу талтай.



ҮНДЭСНИЙ ХУВЦАСНЫ  
ОЁДОЛ, ЭСГҮҮР



ЕВРОП ХУВЦАСНЫ  
ОЁДОЛ, ЭСГҮҮР



ГАР УРЛАЛ



## ҮНДЭСНИЙ ХУВЦАСНЫ ОЁДОЛ, ЭСГҮҮР



Монгол үндэсний уламжлалт хийгээд орчин үеийн загвар хийцтэй дээл, хантааз, ууж, цувцай, хүрэм буюу давхац хувцас болон товч шилбэ зангидах, хөөрөгний даалин урлах арга техникийг онол практик хослуулсан хөтөлбөрийн дагуу туршлагатай, чадварлаг багш зааж сургаж байна.



## ЕВРОП ХУВЦАСНЫ ОЁДОЛ, ЭСГҮҮР



Үйлдвэрлэлийн аргаар зориулалтын тоног төхөөрөмж дээр тулгуурлан орчин үеийн загвар хийцийн дагуу гоёлын, энгийн, хөдөлмөр хамгааллын зэрэг төрөл бүрийн хувцас, цаашлаад цүнх, бүс болон бусад жижиг эдлэлүүдийг савхиар урлах арга технологийг хөтөлбөрийн дагуу зааж сургаж байна.



## ГАР УРЛАЛ



Гар урлалын сургалтаар монгол үндэсний хээ угалзуудыг зүү ороох техникээр хөөрөгний даалин, аяганы уутан дээр шаглах, зээгт наамал, эсгий урлал, савхин материалаар гоёл чимэглэл, бэлэг дурсгалын олон төрөл зүйлийн бүтээгдэхүүн урлах техник, арга барилыг зааж сургадаг.

# ДАГАЛДАХ СУРГАЛТ, СЕМИНАРУУД



Хоолны хичээл

Дээрхи үндсэн сургалтуудаас гадна хамтран ажилладаг байгууллагуудаас мэргэжлийн багш, сургагч нарыг урьж өрхийн санхүү хөтлөх, бичил бизнес эхлүүлэх, хуримтлалын бүлэг байгуулах зэрэг эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлуудаар мэдээлэл танилцуулга хийх, зөвлөгөө өгөх, төрөл бүрийн хоолны сургалт явуулах зэргээр иргэдэд шаардлагатай бусад сургалтуудыг явуулж байна.

## ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА

Өрхийн амьжиргаа сургалтын төв нь хамрагдсан оюутнуудтайгаа байнгын эргэх холбоотой ажиллахыг эрмэлздэг бөгөөд энэ хүрээнд тэднийг ажлын байранд зуучлах, хэрэгцээт мэдээллээр хангах, хийсэн бүтээгдэхүүнээ зарж борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор төрөл бүрийн үзэсгэлэн худалдаанд хамруулж, хамтран оролцдог.

## БИЧИЛ САНХҮҮЖИЛТ

Манай сургалтын төвөөс явуулж буй бас нэг онцлог үйл ажиллагаа бол төгсөгчдийнхөө дунд сонгон шалгаруулалт явуулж, ажлын байр бий болгож, орлогоо нэмэгдүүлэх бололцоог олгох зорилготой бичил санхүүжилтийг хүүгүй, хөнгөлөлттэй, уян хатан нөхцөлөөр жил бүр олгодог.



Үндэсний хувцасны сургалт



Төгсөлтийн зугаалга



Бичил бизнесийн дэмжлэг олгосон нь



Сонгинохайрхан дүүрэг,  
7-р хороо, Мон-Лаа 4-15



70135052, 98895052  
Факс: 70135051



info@caritasmongolia.org  
www.caritasmongolia.org